



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/505

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын хатуу хучилттай авто замд шаардлагатай зам арчилгааны бодис, давсны нөөц худалдан авах 20,000,000 (Хорин сая) төгрөгийн зардлыг аймгийн Замын сангийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

2.Дээрх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д, арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д тус тус даалгасугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ